



БАТЛАВ.
МУИС-ИЙН ЗАХИРЛЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



**БИЗНЕСИЙН СУРГУУЛИЙН СУРГАЛТЫН ТОНОГ
ТӨХӨӨРӨМЖ НИЙЛҮҮЛЭХ ҮНИЙН САНАЛ АВАХ
ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ**

Тендер шалгаруулалт/гэрээний нэр: *Бизнесийн сургуулийн сургалтын тоног
төхөөрөмж нийлүүлэх*

Дугаар: МУИС/201910068

УЛААНБААТАР

2019 ОН

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Монгол улсын их сургууль нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос “**Бизнесийн сургуулийн сургалтын тоног төхөөрөмж нийлүүлэх**” тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх барааны техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг **2020 оны 06 дугаар сарын 19-ны өдрийн 11 цаг 00 минутаас** өмнө **Цахим худалдан авах ажиллагааны систем (www.tender.gov.mn)-д өөрийн аж ахуйн нэгжийн хувийн нууцлалын кодоор нэвтрэн орж тендерийн материалаа цахим хэлбэрээр ирүүлнэ.**

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **2020 оны 06 дугаар сарын 19-ны өдрийн 11:30 минутад** нээнэ.

Дотоодын давуу эрх тооцохгүй.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 6-р хороо, Их сургуулийн гудамж-1,
МУИС-ийн Номын Сан 5 давхар 514 тоот,
Мэдээллийн Технологийн Газар. Н.Золбаяр Холбоо барих: 99084295**

Хоёр. **ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА**

- | | |
|---|--|
| 1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа | 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна. |
| 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт | 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ. |
| 3. Тендерийн иж бүрдэл | 3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:
(а) Үнийн санал;
(б) Үнийн боло нийлүүлэлтийн хуваарь;
(в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
(г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
(д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.] |
| 4. Тогтмол үнэ | 4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана. |
| 5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд | 5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.
5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ. |
| 6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа | 6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна. |
| 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх | 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь ТШӨХ-д заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага |

үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.

**8. Гэрээ
байгуулах эрх
олгох тухай
мэдэгдэл**

8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<p>Тендерт оролцогч дараах нэмэлт материалыг өөрийн тендерт хавсралтаар ирүүлнэ. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Тендерийн маягтыг ТББ-ийн МАЯГТ-ын дагуу бэлтгэж, баталгаажуулан ирүүлнэ, 2. Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, 3. Тендерт оролцогч ТӨӨЗ-ын 4.2.1 - 4.2.9-д дурдсан нөхцөл үүссэн эсэх тухай мэдэгдлийг захиалагчид бичгээр гаргаж ирүүлнэ, 4. Татварын ерөнхий газрын www.e-tax.mta.mn сайтыг ашиглан цахим тодорхойлолтыг тендерийн нээлт хийсэн өдрөөр ирүүлнэ, 5. 2019 оны жилийн эцсийн санхүүгийн аудитлагдсан тайлан ирүүлнэ, 6. Түргэн хөрвөх хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: Санал болгож буй үнийн дүнгийн 100%-иас багагүй байна, 7. 2019 онд хийж гүйцэтгэсэн ижил төстэй ажлын мэдээлэл санал болгож буй үнийн дүнтэй хоёр ажлын гэрээ, гэрээ дүгнэсэн акт ирүүлэх/ 8. Харилцагч банкнаас хугацаа хэтэрсэн зээл, зээлийн өргүй талаарх тодорхойлолт ирүүлэх 9. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын тодорхойлолт ирүүлнэ. 10. Гэрээний ерөнхий болон тусгай нөхцлийг хүлээн зөвшөөрч буй мэдэгдэл ирүүлнэ, 11. Тендерт оролцогчийн ирүүлсэн саналыг олон нийтэд мэдээлэхэд татгалзах зүйлгүй тухай тендерт оролцогчийн албан мэдүүлэг ирүүлнэ, 12. Барааг техникийн тодорхойлолт тус бүрээр нь харьцуулалт хийж ирүүлнэ 13. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ. 14. Тендерийн баримт бичгийн ТШӨХ-нд заасан шаардлагыг хангаагүй, шаардсан материалуудыг ирүүлээгүй нь тендерээс татгалзах үндэслэл болно.
	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь: Уг тендер нь цахим тендер шалгаруулалтын журмаар зохион байгуулагдаж байгаа тул тендерт оролцогч нь Цахим худалдан авах ажиллагааны систем (www.tender.gov.mn)-д өөрийн аж ахуйн нэгжийн хувийн нууцлалын кодоор нэвтрэн орж тендерийн материалаа цахим хэлбэрээр ирүүлнэ. /2020 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 11 цаг 30 минутаас өмнө/</p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газрын хаяг нь дор өгөгдөв. Үүнд: Байшин, гудамжны нэр: МУИС-ийн Номын сангийн байр Давхар болон өрөөний дугаар: 5 давхар, 514 тоот Аймаг, хот: Улаанбаатар хот Улс: Монгол Улс Тендерийн нээлт хийх огноо, цаг нь: Огноо: 2020 оны 06 дугаар сарын 19 -ны өдөр Цаг: 11 цаг 30 минутанд</p>
ТӨӨЗ 6.2	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: Багцгүй</p>

Гурав. **ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ**

1. **Барааны тодорхойлолт:**
2. **Баглаа, боодол:** Зориулалтын стандарт сав баглаа боодолтой байх
3. **Бараа хүргэх газар:** [Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Бага тойруу, Их сургуулийн гудамж, МУИС-ийн хичээлийн 4 байр 314 тоот, Холбоо барих утас 75754400(4147)]
4. **Бараа нийлүүлэлтийн хуваарь:**

БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

Нэр	Тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
Иж бүрэн компьютер		6		МУИС – Хичээлийн 4 байр 314 тоот	Гэрээ байгуулсан өдрөөс хойш ажлын 10 хоног	Гэрээ байгуулсанаас хойш ажлын 20 хоног	
Телевизор		1					
Дэлгэц		5					
Ус цэвэршүүлэгч		2					
Хөргөгч		1					

**МУИС-ИЙН БИЗНЕСИЙН СУРГУУЛИЙН СУРГАЛТЫН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ 2020 ОНЫ
ХУДАЛДАН АВАЛТААР АВАХ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ТОДОРХОЙЛОЛТ**

№	Тоног төхөөрөмж	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Шаардлага	Зураг
1	Иж бүрэн компьютер	Ширхэг	6	<p>Процессорын нэр , хурд: Intel Core i7-8700 3.2Ghz -ээс багагүй Санах-Ойн багтаамж RAM: 8GB DDR4 at 2666MHz -аас багагүй Хадгадах төхөөрөмжийн багтаамж HDD: 500GB-аас багагүй 7200RPM 3.5” hard drive- аас багагүй SSD: 256GB-аас багагүй Graphics card: Intel HD Graphics Холболтууд: DP, USB, LAN, Audio Гар/Keyboard/: USB, Стандарт товчлууртай, Англи үсэгтэй Хулгана: USB Dell брэндийн optiplex 7060mt-тэй дүйцэхүйц Холболт: VGA, DP Diagonal Veiwng Size 58.42cm(23.0 inch) Aspect Ratio – Widescreen 16:9 Panel Type, Surface TN Optimal Resolution 1920x1080@60hz Contrast Ratio 1000:1 Brightness 250cd/m2 (typical) Response Time 8ms typical (normal mode) Viewing Angle 178 vertical/ 178 horizontal Color Support 16.7 million colors Dell брэндийн E2318H-дэлгэц эсхүл түүнтэй дүйцэхүйц</p>	 
2	Телевизор	Ширхэг	1	<p>Хэмжээ: 65 - аас дээш инчийн LED, Curved биш, Хананд суурилуулах боломжтой, Холболт: VGA, HDMI, Audio Resolution 1080p -ээс багагүй,</p>	

3	Дэлгэц	Ширхэг	5	<p>Холболт: VGA, DP Diagonal Veiwng Size 58.42cm(23.0 inch) Aspect Ratio – Widescreen 16:9 Panel Type, Surface TN Optimal Resolution 1920x1080@60hz Contrast Ratio 1000:1 Brightness 250cd/m2 (typical) Response Time 8ms typical (normal mode) Viewing Angle 178 vertical/ 178 horizontal Color Support 16.7 million colors Dell брэндийн E2318Н-дэлгэц эсхүл түүнтэй дүйцэхүйц</p>	
4	Ус цэвэршү үлэгч	Ширхэг	2	<p>ШУА, Геоэкологийн хүрээлэн, Мэргэжлийн хяналтын газраас хянагдсан, цэвэр усны MNS-5007-2003 стандартыг хангасан, Багтаамж 4л, үүнээс хүйтэн ус 2л, халуун ус-2 л-ээс тус тус багагүй байх, хоногт 2160 л-ээс багагүй ус шүүх бүрэн чадалтай, /255мм(W)*482мм(D)*1150 мм (H)/ -ээс багагүй, Ус нөөцлөх хангалттай багтаамж, ус цэвэршүүлэх өндөр хүчин чадал: цагт 30л Халуун уснаас хамгаалах түгжээтэй байна. Усны температур халуун ус 75-90 градус, хүйтэн ус 4-10 градус. Magic WPU-8200F –тэй дүйцэхүйц</p>	
5	Хөргөгч	Ширхэг	1	<p>Өнгө: Цагаан Багтаамж: 40 литр буюу түүнээс дээш Хөргөлтийн систем: Digest Дуу чимээ багатай, үнэр дарагч, нянгий эсрэг хамгаалалттай, мөсний савтай, цантдаггүй Хэмжээ: 501x449x470 Эрчим хүчний хангамж: 220V/50Hz байна</p>	

Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ**

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

4. Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгдөнө.

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БҮЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхгүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | | |
|--|-------|--|
| 1. Шалгах болон турших | 1.1. | Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана. |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. | Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх | 3.1. | Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна. |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх | 4.1. | Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томьёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно. |
| 5. Баталгаат засварын хугацаа | 5.1. | Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа [тоо] жил байна. |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах | 6.1. | Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй. |
| 7. Төлбөр | 7.1. | Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш [ГТН-д заасан тоо] хоногийн дотор шуурхай хийнэ. |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь | 8.1. | Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө. |
| 9. Алданги оногдуулах | 9.1. | Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. |
| 10. Үүргээ биелүүлээгүй -гээс гэрээг цуцлах | 10.1. | Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна. |
| 11. Маргааныг шийдвэрлэх | 11.1. | Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана. |

Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- | | |
|---|---|
| 1. Шалгах болон турших (ГЕН – 1) | 1.1. Барааг мэргэжлийн хүмүүсээс бүрдсэн комисс, нийлүүлэгч талаас хамаарах ажилтан нар шалгалт болон туршилт хийнэ. |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2) | 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:
1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;
2) барааг хүргэсэн тухай баримт
3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;

Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.

2020 оны 07 дугаар сарын 10 |
| 3. Баталгаат засвар (ГЕН-5)
Чанарын баталгаа | 2.2. Гүйцэтгэгч тал бүрэн хариуцна.
5.1. Баталгаат засвар шаардлагатай. Баталгаа хугацаа- Компьютер, Телевизор – 3 жил, бусад тоног төхөөрөмж 6 -12 сар

Чанарын баталгаа 5 хувийг банкинд байршуулж нотолгоог ирүүлнэ. |
| 4. Төлбөр (ГЕН – 7) | 7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:
Урьдчилгаа төлбөр олгохгүй
Барааг хүлээн авахад төлөх төлбөр: Барааг хүлээн авсанаас хойш ажлын 5 хоногийн дотор гэрээний нийт үнийн дүнтэй тэнцэх дүнг нэхэмжлэх болон захиалагчийн хүлээн авсан тухай актыг үндэслэн төлнө. |
| 5. Алданги оногдуулах (ГЕН - 9)¹ | 9.1. Алданги оногдуулах хувь: Хугацаа хоцорсон хоног бүр 0,1%-ийн алданги тооцно.

Алдангийн нийт дүн: 10%-иас хэтрэхгүй байна. |

¹ Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

ЗАХИАЛАГЧ	НИЙЛҮҮЛЭГЧ
_____	_____
(Тамга, тэмдэг)	(Тамга, тэмдэг)
_____	_____
(Гарын үсэг)	(Гарын үсэг)
_____	_____
(Албан тушаал)	(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны ____ сарын ____ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг _____ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь _____ нэр төрлийн барааг _____ оны __ дугаар сарын __-наас _____ оны __ дугаар сарын __-ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Бусад шаардлагатай баримт бичиг³;
Үнийн санал;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
Санхүүжилтийн хуваарь.

² Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

³ Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
*[Гарын үсэг]*_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
*[Гарын үсэг]*_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]